

地震から身を守るためのアドバイス **モンゴル語**

Газар хөдлөлтөөс биеэ хамгаалах зөвлөмж



Сэндай Аялал жуулчлал Олон Улсын Харилцааны төв(СЭНТИА)

Газар хөдлөлтийн талаар суралцъя

Сэндай бол, өдийг хүртэл хэд хэдэн удаа газар хөдлөлтийн уршгийг амсаж ирсэн. Тэр үед, яг юу болсныг хөршүүдээсээ асууцгаая.

1978оны 6 сарын 12ны орой, Мияги орчимд М7.4 газар хөдлөлт болж, Сэндай хотод барилгын блок нурах зэргээр олон хүний амь эрсэдсэн. 2011оны 3 сарын 11ний үдээс хойш, Тохокү бүс нутгийн Номхон далайн хэсэгт үүссэн үнэмлэхүй газар хөдлөлтийн (М9.0) уршгаар, Зүүн Японы гамшиг үүсэж, Сэндай хотод л гэхэд Миягино Вакабаяши дүүргүүдийн далайн эрэг орчмоор олон хүн цунамигаар нас барсан.

* М магнитудь нь газар хөдлөлтийн далайцыг илэрхийлэх нэгж.

Газар хөдлөлт яагаад аймшигтай вэ?

Гал түймэр



Газар хөдлөлтийн дараа, гал гарах магадлалтай. Ялангуяа Барилгын төвлөрөлт ихтэй газарт хот даяар тархах эрсдэлтэй.

Цунами



Далайд газар хөдлөлт үүссэн тохиолдолд, цунами үүсэх эрсдэл буй. Далай болон голын ойр буй хүн болгоомжтой байх хэрэгтэй.

Барилга нуралт



Гэр болон барилга нурж, хүн доор нь дарагдах явдал байна.

* Шинэ барилга (1981 оны хуулийн шинэчлэлийн дараа баригдсан барилгууд) бол харьцангуй бөх.

Нурж ирэх болон унаж ирэх зүйлүүд



Тавилга болон компьютер, авжуур дээрээс унаж ирэх болон, хагарсан шил дээр гишгэж гэмтэх эрсдэл байна. Гадаа байгаа тохиолдолд автомат худалдаалагч, хана, самбар гэх мэт зүйлс унаж, тэдгээрийн доор дарагдах аюул буй.

Газар нурах, асга гулгах



Уулны огцом хэсэг болон асга ганганы ойр буй хүнд болгоомжлол хэрэгтэй

Зүүн Японы их гамшгаар тулгарсан бэрхшээлүүд

① Мэдээлэл авч чадахгүй

Газар хөдлөлтийн дараах хэсэг хугацаанд, гар утас болон интэрнэтээр холбогдоход хүндрэлтэй болсон. Цахилгаан тасарсны улмаас гар утсаа цэнэглэж чадахгүйд хүрсэн нь их бэрхшээлтэй байв. Яг одоо юу болж буйг мэдэхгүй мөн гэр бүл найз нөхөдтэйгөө холбогдож чадахгүй зовсон хүн зөндөө байсан.

② Тог тасарсан

Хурдандаа, газар хөдлөлтийн дараахи өдөр, гамшигт их нэрвэгдсэн бүс нутгийг үл тооцвол долоо хоногтоо тог ирсэн боловч, гэрэлгүй харанхуй орой сэтгэл таагүй байсан.



③ Ус тасарсан

Олонхи бүс нутагт ус тасарч, хэвийн байдалд ортлоо нэг өдрөөс бүтэн долоо хоног зарцуулагдсан. Уух ус болон өдөр тутмын хэрэглээний усаар гачигдаж хүндрэлтэй байсан.



④ Жорлонгийн ус ашиглаж чадахгүй

Ус тасарч, жорлонгийнхоо усыг татаж чадахгүй бэрхшээлтэй байсан. Банддаа ус дүүргэсэн байсан хүмүүс харин тэр усаа хэрэглэсэн.

⑤ Хийн түлш тасарсан

Ихэнх бүс нутагт, хийн түлш иртлээ сар орчим болсон. Үүний улмаас, хоолоо хийж чадахгүй, дулаан байхгүй, усанд орж чадахгүй машид асуудалтай байсан.

⑥ Хүнсний зүйлээр гачигдсан

Удаан оочерлосонч гэсэн их зүйл худалдаж авч чадахгүй, хүнсний зүйлээр гачигдсан.

⑦ Тээвэр зогссон

Галт тэрэг, хурдан галт тэрэг болон метро хэсэг хугацаанд зогсож, автобус мөн тоо нь цөөрсөн. Бензиний дутагдалд орж, машин мотоциклоо унаж чадахгүй хэцүү байв. Дугуй унах хүн нэмэгдсэн.

Газар хөдлөлт болохоос өмнө хийж чадах зүйл

1 Төсөөлөөд бодож үзэх

Одоо газар хөдөлвөл яах вэ? Бүр шөнөөр хөдөлвөл яах вэ? Олон тохиолдлыг төсөөлөнгөө, гэр бүл болон найз нөхөдтэйгөө ярилцах нь чухал.



Б) Таазнаас дүүжилдэг авжуур бол хөнгөхөнийг хэрэглэсэн нь дээр

С) Орныхоо хажууд таавчиг, радио, гар чийдэн бэлд Унтаж байхад чинь газар хөдөлвөл, юу болох билээ? Хагарсан шилэн дээр гишгэж гэмтэхгүйн тулд, таавчиг бэлдсэн нь дээр. Тог тасарна гэж тооцоолоод, радио болон гар чийдэн бэлдэе.

Д) Гал унтраагч бэлд

Гал унтраагч, гэр ахуйн бараа зардаг газраас авч чадна.


2 Гэр доторхи аюулгүй байдлын хангалт

А) Тавилга болон цахилгаан хэрэгсэл унахаас болгоомжил

Чичиргээнээс болж, тавилга болон цахилгаан хэрэгсэл унах магадлал байна. Эдгээр зүйлийг, гэр ахуйн бараа зардаг газраас тогтоогч аваад бэхлэхийг аюулгүй.

Өндөр газар хүнд зүйл тавих нь аюултай

Тавилга нураад гарах гарцыг чинь хаачиж байгаа юм биш биз?



3 Гэрийн ойр орчим, замын аюулгүй байдлыг шалга

а) Гэрийнхээ ойролцоох аюулгүй газрыг шалга

Цэцэрлэг гэх мэт, дээрээс хүнд зүйл унаж ирэхгүй газар нь аюул багатай. Их гал түймэр үүсэж, бүр аюулгүй газарлуу шилжих хэрэгтэй болсон үед зугтаж чадахаар олон гарцтай газрыг сонгоорой.

б) Далайн эрэг орчмоор, цунамигаас зугтаж гарах аюулгүй байдлыг нягтлаарай

Өндөр газар ба цунамигаас хоргодох барилга(яаралтай үед хоргодож болно гэж заагдсан газар)-н байршлыг урьдчилан шалгаарай.

Хүнд зүйлийг доош нь тавь.

Тавилгаа бэхл. Хэрвээ, унасан тохиолдолд ч хаалга үүдийг бөглөхгүй байхаар газарт байрлуул.

Телевизээ мөн бэхл.

Орныхоо дэргэд зузаан ултай таавчиг тавь. Орны ойролцоо радио болон гар чийдэн бэлд.

COLUMN

Өмнө нь зугтах замаа шалгасан байсан тул, газар хөдлөлтөөр шууд зугтаж чадсан. Гэхдээ, харанхуй байсан бол юу ч харагдахгүй их аймаар байх байсан байх. Цаашид, хэрвээ шөнө ийм юм тохиолдвол яах вэ гэдгийг бодолцож, зугтах замаа шалгая гэж бодож байна. (Зүүн японы гамшгийн дурсамжаас)

с) Зугтах үеийн зам чинь аюулгүй юу?

Блокон хавтан хана, автомат худалдааны машин гэх мэт зүйл нурж унаж доор нь дарагдах магадлал өндөр. Мөн нарийн зам дээр блокон хавтан хана, автомат худалдааны машин гэх мэт зүйл нурж унаж замыг бөглөх магадлал ч бий.

④ Хоргодох байрны талаар

Сэндай хотод, хотын бага болон дунд сургуулийг хоргодох байр болгож тогтоосон байдаг. Өөрийн гэрийн ойролцоох хоргодох байр болон тэр хүртлэх аюулгүй замыг өөрөө алхаж үзэн нягтлаарай.

⑤ Гэр бүл, найз нөхөдтэйгөө холбогдох аргаа урьдчилан тохиролцоорой

Зүүн Японы гамшгийн үеэр хэсэг хугацаанд гар утас болон смарт утаснууд холбогдоход асар хүндрэлтэй байсан. Гамшгийн үер гэр бүл болон найз нөхөдтэйгөө яаж холбоо барих, хаана уулзах вэ гэдгээ ярилцаарай.

☞ 7-р хуудасны [гамшгийн үеийн дамжуулах самбар] -г ашиглаарай

⑥ Зугтах үед, авч явах зүйлээ бөөгнүүлээд тавь

Хоргодох үед, хэзээд ч бариад явахад бэлнээр, хэрэгцээт зүйлсээ цүнх савандаа бэлдээд тавьчихвал зүгээр. Эм, нүдний линз угаагч гэх мэт өөртөө хэрэгтэй зүйлээ ч бас шууд авч явж чадахаар бэлдээрэй. Ус тасарч, идэх юм олдохгүй байдалд бэлдэж, лаазалсан хүнс болон савтай усыг гэртээ бэлдээд тавьчихвал зүгээр шүү.



Цүнхэндээ хийх зүйл

- Оршин суух иргэний үнэмлэхийн
- Бэлэн мөнгө(зоос олноор)
- дотуур хувцас • оймс • бээлий
- Борооны хувцас(шүхэр)
- гар чийдэн • радио
- Түргэн тусламжийн хэрэгсэл • шүдэнз
- Гялгар уут • бэлэн хүнс
- Эм, линз угаагч, ариун цэврийн хэрэгсэл гэх мэт өөртөө хэрэгтэй зүйл

⑦ Орон нутгийн хүмүүстэй холбоо сүлжээтэй байх

Гамшиг гарсан үед, бие биендээ тусалвал, их том дэмжлэг болно. Ойр орчмынхоо хүмүүстэй өдөр тутмын мэндтэй байх нь, гамшиг болсон үед хэрэг болно шүү.

Хөрш айлд чинь ямар хүн амьдардаг вэ мэдэж байна уу?

⑧ Мэдээлэл олж авах аргаа нягталж үз

Гамшгийн үед, мэдээлэл байхгүй бол сэтгэл амар байж чадахгүй ээ. Яаж мэдээлэл олж авах вэ мэдэж авцгаая

☞ 8-р хуудас

Мэдэж байхад илүүдэхгүй мэдлэгүүд

① Газар хөдлөлтийн чичрэлтийн хүчийг Шиндо(чичирхийллийн хэмжээ)газар хөдлөлтийн далайцыг М(Магнитудь) гэж нэрлэдэг.

Газар хөдлөлтийн энергийн далайцыг илэрхийлдэг [М(Магнитудь)] нь дэлхий даяар адилхан нэршилтэй, харин газар хөдлөлтийн хүчийг заадаг [Шиндо(чичирхийллийн хэмжээ)] нь, улс бүрт өөр өөр нэршилтэй байдаг байна.

Японы ус цаг уурын хүрээлэнгээс мэдээлдэг Чичирхийллийн хэмжээ (Цаашид ЧХ гэж товчлоно)

しんど よん
震度 4
(shindo yon)
ЧХ4

Алхаж буй хүн ер нь л барагтаа чичрэлтийг мэдэрнэ. Унтаж буй хүн барагтаа нүдээ нээнэ.

しんど ご じやく
震度 5 弱
(shindo go jaku)
ЧХ5сул

Ширээн дээр буй сав суулга болон тавиур дээр буй ном унах тохиолдол байна.

しんど ご きゆう
震度 5 強
(shindo go kyuu)
ЧХ5хүчтэй

Бэхлээгүй тавилга нурах үе байна. (Зүүн японы гамшгийн үеэрх Тайхаку дүүрэг)

しんど ろく じやく
震度 6 弱
(shindo roku jaku)
ЧХ6сул

Зогсож байх нь ч хэцүү байдал. Бэхлээгүй тавилга ихэнх нь байрнаасаа хөдөлж, унах нь ч байна. Хаалга гацаад онгойхгүй болох явдал ч буй.(Зүүн японы гамшгаар Аоба дүүрэг, Вакабаяши дүүрэг, Изүми дүүрэг)

しんど ろく きゆう
震度 6 強
(shindo roku kyuu)
ЧХ6хүчтэй

Зогсож чадахгүй. Бэхлээгүй тавилга ихэнх нь хөдөлж, унах нь олон болно.(Зүүн японы гамшгийн үеэрх Мягино дүүрэг)

しんど なな
震度 7
(shindo nana)
ЧХ7

Бэхлээгүй тавилганы ихэнх нь хөдөлж, нурж, шидэгдэх тохиолдол байна.

② Газар хөдлөлтийн яаралтай мэдээ

Газар хөдлөлтийн хүчтэй чичиргээнээс өмнө, газар хөдлөлтийг зааж өгдөг программ. Телевиз, радио, гар утас болон смартфон-с тусгай дуугаар мэдээлэл өгнө. (зарим гар утсанд энэ систем ажилладаггүй)

Газар хөдлөлт болчихвол



Гэртээ байгаа үед

1 Толгойгоо хамгаал

Бат бөх ширээний доогуур нуугдаж, толгойгоо хамгаал. Энэ үедээ, ширээн доороос шидэгдэхээс хамгаалж, ширээнийхээ хөлнөөс сайн бариарай. Ширээ байхгүй бол, дэр гэх мэтээр толгойгоо хамгаалаарай.



Их хүчтэй газар хөдлөлт нь жирийн үед 1 минутан дотор зогсдог боловч, зүүн японы гамшгийн үеэр 3 минут хэртэй үргэлжилсэн.

2 Яарч сандран гадагшаа гарахгүй байх

Яаран сандран гадагшаа гарвал эсрэгээрээ аюултай. Гадагшаа гарах үед, дээрээс унаж ирэх зүйлээс болгоомжлоорой.



3 Чичирхийлэлт намдсаны дараа галыг унтраа.

Хүчтэй чичирч буй үед гал руу хамаагүй ойртох нь аюултай. Чичирхийлэлт намдсаны дараа гал унтраагаарай.



4 Хаалга онгойлгож гарах гарцаа бэлд

Барилга хөшигдөөд, хаалга онгойхгүй болох тохиолдол байна. Чичирхийлэлт багасаад ирэнгүүт, аль болох хурдхан хаалга онгойлгож, гарах гарцаа бэлдээрэй. Ялангуяа орон сууц гэх мэт өндөр барилгад гарах гарцаа бэлдэх нь нэн чухал.



Гадаа буй тохиолдолд

1 Блокон хавтан хана, автомат худалдааны машин гэх мэтээс холд

Унаж ирээд дарах аюултай. Шууд холдоорой.



2 Самбар болон цонхны шил унахаас болгоомжил

Барилгын гаднаас холдоорой.



Сургууль болон дэлгүүрт байгаа тохиолдолд

1 Толгойгоо хамгаал

Ширээн доогуур орж, толгойгоо хамгаал. Ширээ байхгүй бол, цүнх зэргээрээ толгойгоо хамгаалаарай.

2 Дээрээс унжиж буй авжиураас болгоомжил.

Хурлын танхим зэрэг газар байх үед, газар хөдлөлтийг мэдэрвэл, авжиур гэх мэт дээрээс унжиж буй зүйлээс болгоомжил. Унаж ирэх аюултай учраас.



3 Яарч сандран гадагшаа гарахгүй байх

Багш болон хариуцагч хүн ирээд авч явтал, сандралгүйгээр үйл хөдлөл хийгээрэй.

Цахилгаан шатан дотор буй үед

Бүх давхрын товчыг дарж, нэн даруй буугаарай.

Машин барьж буй үед

Аажмаар хурдаа багасгаад замын зүүн тал руу зогсоож, машинаа унтраа. Радиогоор мэдээ сонс. Дүрвэх үедээ машинаасаа буугаад алхаж яваарай.



Чичиргээ намдсаны дараа



① Ойр тойрноо хар

Гэр дотор аюулгүй байна уу?
Хийн плеткнийхээ хийг хаасан уу?
Ойр орчимд чинь гал гарч байна уу?
Давтан чичиргээгээр гэр чинь дахин эвдэрч, гал түймэр тархвал хоморгонд нь орох аюултай.
Том газар хөдлөлт болсны дараа, түүнээс бага далайцтай хөдлөлт дахин дахин явагдана. Түүнийг нөөц газар хөдлөлт гэж нэрлэдэг. Газар хөдлөлтийн чичиргээгээр бат бэх байдал нь суларсан барилга нөөц газар хөдлөлтөөр улам эвдрэх тохиолдол байдаг.

② Телевиз, радиогоор мэдээ цуглуул

Газар хөдөлмөгц хэдхэн хором дотор газар хөдлөлтийн далайц болон бүс нутгуудын чичиргээний хэмжээ, цунами үүсэх үү үгүй юу гэдгийг телевиз, радиогоор дамжуулдаг. Их цунами эсвэл цунами-с болгоомжлох мэдээлэл цацагдангуут, NHK нь, Англи, Хятад, Солонгос, Португалиар мэдээ дамжуулдаг. NHK 2-р радио (Сэндай 1089kHz) нь, Япон, Англи, Хятад, Солонгос, Португаль хэлээр давтан давтан мэдээ дамжуулдаг.



③ Цунамигээс болгоомжил

Далайд газар хөдлөлт болвол цунами үүсэх үе байна. Цаг уурын хүрээлэн нь, газар хөдлөлт болсноос 2, 3 минутан дотор, цунами үүсэх үү үгүй юу, цунами ирэх цаг болон ирэх магадлалтай цунамины өндрийг нийтэд зарладаг. Далайн эрэг орчим газар хөдлөлттэй дайралдвал, нэн даруй телевиз, радиогоо чагнаж, цунами ирэх бол, даруй далайгаас холдож, аюулгүй газар луу зугтаагаарай.

Цаг уурын хүрээлэнгээс мэдээлдэг цунамигийн сэрэмжлүүлэг мэдээний ангилал

おおつ なみけいほう
大津波警報
(ootsunami keihou)
Аварга цунами түгшүүр

Их цунами давалгаалан орж ирж хязгааргүй их хохирол учрах

つ なみけいほう
津波警報
(tsunami keihou)
Цунами түгшүүр


Цунамигээс үүдэлтэй хохирол учрах

つ なみちういほう
津波注意報
(tsunami chuuihou)
Цунами сэрэмжлүүлэг

Далай дотор болон далайн эрэг орчмоор аюултай

④ Юуны урьдаар аюулгүй газар луу яв

Унаж ирэх зүйлс, дараад ирэх зүйл байхгүй өргөн газар, хэд хэдэн зугтах замтай газар очих нь аюулгүй. Том гал түймэр гарсан тохиолдолд, улам бүр аюулгүй газар очих хэрэгтэй учраас тэр.



⑤ Ойр тойрныхоо хүнд хэлж мэдэгдэн, бие биендээ туслах

Тусламж хэрэгтэй хүн байвал туслаарай.




⑥ Гэр аюултай бол хоргодох газарлуу яваарай

Хэмхэрсэн гэр дотор байх нь тун аюултай. Өөрт хэрэгтэй багахан ачаагаа аваад хоргодох газарлуу яваарай. Сэндай хот бол, хотын харьяа бага болон дунд сургуулийг хоргодох газар болгон заасан.



⑦ Хоргодохоор гэрээсээ гарах үеийн зөвлөмж

- Керосиноор ажилладаг халаагуураа унтраасан уу шалга
- Цахилгааны товчлуураа хаа
- Хийн түлшний үндсэн эх үүсвэрээр хаа
- Усны крант хаалттай байна уу шалга
- Үнэтэй зүйлс (үнэмлэх, мөнгө, банкны карт зэрэг)-ээ аваарай
- Гар утас, смарт утас, цэнэглэгчээ ав
- Дулаахан хувцасла
- Яаралтай үед хэрэгтэй зүйлсээ хийсэн цүнхээ барь
- Цонх болон хаалгаа түгж
- Гэрийнхэнтэйгээ холбоо барьж чадаагүй бол, очих хоргодох газрынхаа хаягийг хаалган дээрээ бичиж наа



Хоргодох байранд очоод хийх зүйлүүд

① Нэрээ бич

Бүртгэл дээр өөрийхөө нэрийг бичиж үлдээ. Өөрийг чинь тэнд буйг мэдэгдэхийн тулд юм шүү.

② Уух ус, идэх юм, мэдээлэлтэй золгох

Өөрийн хэрэгцээг хангах ус болон идэх юмаа тухай бүр идэх юмаа тухайн үед өөрт хэрэгтэй хэмжээг л аваарай. Хоргодох газар мэдээлэл цуглана. Үг хэл сайн ойлголцож чадахгүй хүн байх юм бол, хэрэв чи орчуулж чадахаар бол, туслаарай. Гэртээ хоргодож байгаа бөгөөд цахилгаан, хийн түлш, ус ашиглаж чадахгүй, хоол хийх боломжгүй байгаа хүн, хоргодох газраас ус, идэх юм авч болно. Түр зуурын жорлон бас хэрэглэж чадна.

③ Бие биедээ туслах

Хоргодох газар бол, хоргодохоор ирсэн хүмүүс өөрсдөө асуудлаа зохион байгуулна. Цовоо цолбиун байгаа хүмүүс, эд зүйлс зөөх, цэвэрлэх гэх мэт, хоргодох газрын зохион байгуулалтын ажилд туслаарай.



Гэр бүл болон найзуудтайгаа холбогдож чадахгүй үед

Гамшиг гарсан үед гар утас, смарт утас холбогдоход хүндрэлтэй болно. Дараах аргуудыг туршиж үзээрэй.

- Гамшигийн бүсээс өөр нутаг холбогдоход амар учир өөр бүс нутагруу холбогдож өөрийн байгаа газраа зааж өг.
- Таксофоны утас холбогдоход хялбар байдаг.
- Утсаар холбогдох боломжгүй бол, мэйл явуулаад үз.
- Гар утас, смарт утасны гамшигийн үеэрх самбарыг ашигла

Гар утас, смарт утасны [Гамшигийн үеийн дамжуулах самбар]

Том хэмжээний гамшиг үүссэн тохиолдолд гар утас болон смарт утасны нүүрэн дээр [Гамшигийн үеийн дамжуулах самбар] гэсэн тэмдэг гарна.

Мэссэж бүртгүүлэх

Гамшигийн үеийн дамжуулах самбар → Бүртгүүлэх → Мэссэжээ бич → Бүртгэ

Мэссэжээ үз

Гамшигийн үеийн дамжуулах самбар → Нягтал → Хүлээн авах хүнийхээ дугаарыг оруул → Хай → Мэссэж чинь гарч ирнэ

Өөрийнхөө хаана байгааг дамжуулах

Том хэмжээний гамшиг болсон үед, элчин сайдын яам болон сургууль, ажилладаг газартаа өөрөө яг одоо хаана байгаагаа дамжуулаарай. Өөрийг чинь хайж буй хүнд таны мэдээллийг өгч чадна.

Гамшигийн үеэр их хэрэглэгддэг япон үгнүүд

| | |
|--|---|
| ひなん 避難 (hinan/Хинан) | Дүрвэх буюу тухайн газраас аюулгүй газар луу шилжих үйл явц |
| とほ 徒歩 (to ho de/Тохо-дэ) | Алхаад явах |
| たかだい 高台 (takadai/Такадай) | Өндөр газар |
| ゆうどう 誘導 (yuudou/Юүдо) | (хүн) тэр газарт очтол нь зааж өгөх явдал |
| うかい 迂回 (ukai/Укай) | Өөр замаар явах |
| あんぴ 安否 (anpi/Анпи) | Тухайн хүн эсэн мэнд үү үгүй юу гэдгийг шалгах |
| おうきゅうしよ 応急処置 (oukyuu shochi/Оокюшөчи) | яаралтай хэрэгтэй байгаа тусламжийг үзүүлэх |
| そな 備える (sonaeru /Сонаэру) | Бэлдэх |
| ていでん 停電 (teiden/Тэйдэн) | Тог тасрах |
| だんすい 断水 (dansui/Дансүй) | ус тасрах. |
| きゅうすいしよ 給水車 (kyuusuissha/Кюусүйшя) | Усны машин |
| ひ 火の始末をする (hi no shimatsu wo suru Хино шимацү о сүрү Галын үндсийг унтраах | гал унтраах |
| ふつう 不通 (futsuu/Фүцүү) | Зам хаагдаж гарах гарцгүй болох |
| うんてん 運転を見合わせる (unten wo miawaseru /Үнтэн о миавасэру) | Замын хөдөлгөөн зогсох Галт тэрэг явахгүй байх гэх мэт |
| きけん 危険 (kiken/Кикэн) | Аюултай |
| きゅうじよ 救助 (kyuujio/Кюужё) | Аврах |
| けいかい 警戒 (keikai/Кэйкай) | Болгоомжлох |
| самата 妨げ (samatage/Саматарэ) | Саад |

| | |
|--|---------------------------|
| すみやかに、ただちに (sumiyaka ni , tadachi ni/ Сүмиякани, тадачини) | Шууд |
| 立ち入り禁止 (tachiiri kinshi/ Тачи-ири кинши) | Дотогш орж болохгүй |
| 通行禁止 (tsuukou kinshi/ Цүүкоу кинши) | Явж орж болохгүй |
| 付近 (fukin/Фүкин) | Ойр орчим |
| ひか 控える (hikaeru/Хикаэру) | аль болох хийхгүй байх |
| 身の安全を確保 (mi no anzen wo kakuho/ Миноанзэн) | Өөрийхөө биеийг хамгаалах |

Мэдээлэл олж авах арга

① Хоргодох газар

Хотын захиргаанаас гаргаж буй мэдээг харж чадна. Чухал мэдээлэл бол англиар цаасан дээр бичиж тавина.

② Радио

СЭНТИА(Сэндай Аялал жуулчлал Олон Улсын Харилцааны төв) нь, Сэндай хот доторхи радионуудтай хамтарч, радиогоор дамжуулан англи хэл болон хятад хэл зэргээр амьдралд хэрэгтэй мэдээллийг хүргэж байна.

СЭНТИА-тай хамтарч гадаад хэлээр мэдээ дамжуулж буй радионууд

| | |
|------------|---------|
| Дэйт эф эм | 77.1MHz |
| Радио3 | 76.2MHz |

| | |
|---------------|---------|
| Эф эм Тайхаку | 78.9MHz |
| Эф эм Изүми | 79.7MHz |

③ Сэндай хот гамшигийн үед олон хэлээр туслах төв

Том хэмжээний гамшиг үүссэн тохиолдолд, Сэндай хот нь, Сэндай Олон Улсын төв дотор 「Сэндай хот гамшиг олон хэлээр туслах төв」 -г байрлуулж, англи хэл, хятад хэл, солонгос хэлээр мэдээлэл түгээж байна. Гадаад хэлээр тусламж хэрэгтэй үед ч Сэндай олон улсын төврүү холбоо бариарай.

Хаяг : Сэндай хот Аоба дүүрэг Аобаяма Сэндай
Кокүсай центр дотор
Утас: 022-224-1919 / 022-265-2471
Факс:022-265-2472
<http://int.sentia-sendai.jp/saigai/>

СЭНТИА МЭЙЛ

Сэндай Аялал жуулчлал Олон Улсын Харилцааны төв (СЭНТИА) нь, Япон хэл, Англи хэл, Хятад хэл, Солонгос хэлээр мэйл түгээж, олон төрлийн мэдээ хүргэж байна. Гамшиг үүссэн үед ч мэйлээр мэдээлэл хүлээж авах боломжтой.

<http://int.sentia-sendai.jp/e/activity/mailmagazine.html>

СЭНТИА фэйсбүүк · твиттер

[Лайк] товчийг дарж бүртгүүлвэл шинэчлэгдсэн мэдээг хүлээн авч чадна.

Фэйсбүүк дээр [Sendai International Relations Association] гэж хайгаарай.

Твиттерт дагасанаар шинэ мэдээлэл авах боломжтой.

Твиттер дээр [@ SENTIA_info] -г дагаарай.

Газар хөдлөлтөөс биеэ хамгаалах зөвлөмж

2019оны Дөрөвдүгээр сар
Хэвлэлтэд бэлдэж, гаргасан :Сэндай Аялал
жуулчлал Олон Улсын Харилцааны төв (СЭНТИА)

Дизайн : Фүмиз Ямаока , Акихиро Такэтоши
Зураг : Кохарү Абэ